

Эрдэм шинжилгээний өгүүлэл
УДК 327 (5-01)
DOI 10.18101/2949-1657-2024-4-50-61

Дэлхийн геополитикийн өөрчлөлт зүүн хойд азийн бүс нутаг болон монгол улсын аюулгүй байдалд нөлөөлөх нь

© Пурэвдоржийн Батжаргал

тэргүүлэх судлаач
Стратегийн судалгааны хүрээлэн,
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
Төрийн ордон 11, 8 давхар,
Самбуугийн гудамж-11, Чингэлтэй хороолол,
Ulaanbaatar 15141, Mongolia
batjargal@iss.gov.mn

Хураангуй. Өнөөгийн олон улсын байдал хурдацтай өөрчлөгдөж, улам тогтворгүй, урьдчилан таамаглах аргагүй болж байна. Олон улсын харилцаа, геополитикт томоохон өөрчлөлтүүд гарч, бүс нутгийн аюулгүй байдлын театруудад цэрэг, улс төрийн тааламжгүй хүчин зүйлүүд гарч ирснээр олон улсын аюулгүй байдлын орчин улам дордож, нарийн төвөгтэй өөрчлөлтүүд үргэлжилсээр байна. Зүүн хойд Азийн бүс нутагт геополитикийн нөхцөл байдал үүссэн "Хүйтэн дайн" үргэлжилсэн нөхцөл тодорхой. Зүүн хойд Ази нь эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй, харьцангуй сайн интеграцчилсан орнуудыг агуулдаг боловч итгэлцлийг бэхжүүлэх механизм, аюулгүй байдлын хамтын ажиллагаа дутмаг байгаа. Тийм учраас Зүүн хойд Азийн бүс нутаг нь нутаг дэвсгэрийн маргаантай асуудлаас үүдэн мөргөлдөөн гарах магадлал өндөртэй бүс нутаг гэж тооцогддог.

Түлхүүр үг: дэлхийн шинэ дэг журам, эрсдэл ба сорилт, Зүүн хойд Ази, Монгол.

Ишлэл

Пурэвдоржийн Батжаргал. Дэлхийн геополитикийн өөрчлөлт зүүн хойд азийн бүс нутаг болон монгол улсын аюулгүй байдалд нөлөөлөх нь // Зүүн зүгийн вектор: түүх, нийгэм, улс. 2024:4: 50–61 (монгол хэл дээр)

Нэг. Дэлхийн геополитикийн нөхцөл байдал

Өнгөрсөн XX зуунд дэлхийн нөлөө бүхий улс орнуудын геополитикийн өрсөлдөөн II дайны дараа үндсэндээ “цэгцэрч” капиталист, социалист хоёр системийн хоорондын өрсөлдөөн болон хувирч, улмаар хүйтэн дайны эрин үеийг туулсны эцэст АНУ тэргүүтэй Өрнөдийнхний ялалтаар дууссанаар олон улсын харилцаанд нэг туйлт систем тогтсон болно.

Гэвч дэлхийн түүхэнд “Монголын их амар амгалангийн үе” шиг байдал дахин давтагдсангүй. Хүйтэн дайны үеийн систем хоорондын геополитикийн сөргөлдөөн ардчилсан болон авторитар тогтолцооны хоорондох тэмцлээр үргэлжилж, үүний сүүдэрт эрчим хүчний нөөц, байгалийн баялагийн орон зайн төлөөх өрсөлдөөн өрнөж, шашны хэт даврагсад, олон улсын терроризмоор “хүч нэмсэн” билээ. Хүйтэн дайны дараах геополитикийн сөргөлдөөнд Ойрхи Дорнод, Хойд Африкийн ихэнх орнууд өртөж, үр дүнд нь Европыг бүрхсэн дүрвэгсэдийн шинэ урсгал бий болж, түүний эдийн засгийн сөрөг үр дагавар жижиг, буурай хөгжилтэй орнуудад хүндээр туссан юм.

Эдүгээ олон улсын аюулгүй байдлын орчин тогтворгүй, урьдчилан таамаглахад төвөгтэй үйл явдал хурдацтай өрнөж, дэлхийн геополитик, олон улсын харилцааны түвшинд шилжилтийн үеийн томоохон өөрчлөлт явагдаж байна. Энэ үе магадгүй 2040-өөд он хүртэл үргэлжилж, аюулгүй байдлын орчны суурь динамик хөдөлснөөр хамрах цар хүрээ, далайц дэлхийн түүхэнд урьд өмнө байгаагүйгээр өрнөж ч болзошгүй байна. Олон улсын харилцааны шилжилтийн гэх энэ цаг үеийг зарим шинжээчид Өрнөдийн давамгайллын дараах шинэ дэг журам тогтох явц хэмээн харж байна.

Сүүлийн жилүүдэд бүс нутгуудын аюулгүй байдлын орчинд¹ цэрэг, улс төрийн тааламжгүй хүчин зүйлс нэмэгдэж, олон улсын аюулгүй байдлын нөхцөл хүндэрч, төвөгтэй өөрчлөлтүүд үргэлжилсэн хэвээр байна. Олон улсын, түүний дотор томоохон улс орнуудын өнөөгийн харилцаа, цаашдын төлөв ээдрээтэй, харилцан уялдаа бүхий шинэ болон хуучин зөрчлүүд үргэлжилсэн хэвээр, геосөргөлдөөнд томоохон орнуудын оролцоо идэвхитэй хэвээр байна.

Дашрамд дурдахад АНУ-ын 2017, 2021, 2022 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалуудад² БНХАУ, ОХУ-ыг стратегийн өрсөлдөгч, сөргөлдөгч гэж тодорхойлсноор үндсэндээ их гүрнүүдийн өрсөлдөөн бий болоод байгааг албажуулсан хэрэг болсон. Тэгвэл 2021 оны долоодугаар сард батлагдсан ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид³ Оросын хилийн дагуух НАТО-ын цэргийн дэд бүтцийн байршил болон АНУ-ын пуужингаас хамгаалах цогцолбор зэрэг нь стратегийн тогтвортой байдлыг алдагдуулж байна хэмээн тодорхойлсон байдаг.

Дээр дурдсанчлан олон улсын тогтолцоо, түүний төлөв байдал болон өөрчлөлтөд давамгайлах үүрэг гүйцэтгэдэг томоохон улс орнуудын харилцаанд зарим төвөгтэй байдал үүсч, тэдний хооронд геополитикийн шинж чанартай “тэмцэл” үргэлжилсэн хэвээр байна. Үүний зэрэгцээ дэлхийн “халуун цэг”-үүдийн тоо буурах биш харин нэмэгдэж ойрын ирээдүйд байдал сайжрах төлөвгүй байна.

Томоохон хүчнүүдийн хооронд геостратегийн “тоглоом” нэгэнт өрнөж тэд АНДБН, Европ болон Ойрхи Дорнод гэсэн газарзүйн 3 хэсэгт анхаарал илүүтэй хандуулж байсан бол ойрын ирээдүйд Африк тив геополитикийн тэмцлийн шинэ талбар болох хандлагатай байна.

Ийнхүү аюулгүй байдлын уламжлалт сорилтуудтай зууралдаж байхтай давхацан байгаль цаг уурын өөрчлөлт, дайн, зэвсэгт мөргөлдөөн, дотоодын тогтворгүй байдлаас үүдэлтэй хүмүүнлэгийн болон дүрвэгсэдийн хямрал бодитойгоор нүүрлэв. Цаашид байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан “экологийн дүрвэгсэд” гэсэн шинэ сорилт тулгарах нь ойрхон байна. Мөн шинжлэх ухаан технологийн хурдацтай хөгжлөөс үүдэлтэй шинэ

¹ **Аюулгүй байдлын орчин** гэдэг тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлийн нэгдэл гэж ойлгож болно. Тухайлбал дэлхийн болон бүс нутгийн улс төр, эдийн засаг, цэрэг-улс төрийн байдал аюулгүй байдлын гадаад орчинд хамаарах бол нийгэм эдийн засаг, засаг, байгаль цаг агаар гэх мэт хүчин зүйлс аюулгүй байдлын дотоод орчинд хамаарна.

² <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2022/10/Biden-Harris-Administrations-National-Security-Strategy-10.2022.pdf>

³ https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_389271/

сорилтууд бий болж геополитикийн сөргөлдөөн мэдээллийн орон зай болон сансар огторгуйд өрнөж эхэллээ.

Олон улсын аюулгүй байдлын орчныг дэлхий дахины хэмжээнд зураглаж үзвэл эрчимтэй хямрал, зөрчилдөөн бүхий, тэдгээрийг улс төрийн аргаар бус, хүчээр шийдвэрлэх сэдэл давамгайлсан цаг үед бид нэгэнт ороод байна. Ийнхүү геополитикийн орон зайн сөргөлдөөн эдүгээ улам даамжирч бүс нутгийг хамарсан зэвсэгт мөргөлдөөнөөр илрэх болов.

Орос-Украины дайн энэ сөргөлдөөний хамгийн ойрын жишээ болж, эл дайны цар хүрээ, үргэлжлэх хугацаа, олон улсын аюулгүй байдлын орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг одоогоор урьдчилан тооцоход бэрхшээлтэй байна. Дайны улмаас дэлхийн эдийн засгийн өнөөгийн тогтолцоо их гүрнүүдийн геополитикийн дагуу хуваагдах, дайн сунжрах тусам Оросыг далдуур дэмжиж байсан улс орнууд ил гарч де-факто аюулгүй байдлын тогтолцооны шинэ блок үүсч болзошгүй нөхцөл байдал бий боллоо. Олон улсын байгууллагуудын нөлөө, үүрэг, ач холбогдол бүдгэрч улс орнуудын хоорондын зөрчил мөргөлдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх, зогсоох чиг үүрэгтэй НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага үндсэндээ эрх зүйн чадамжгүй институцууд болон хувирав.

Манай умард хөрш ОХУ-ын эргэн тойронд үүсээд буй цэрэг-улс төрийн байдал хүйтэн дайны дараа ач холбогдол алдагдаж эхэлсэн НАТО дахин сэргэж хүрээгээ тэлэх гол шалтаг, шалтгаан болсноос 1992 онд 16 гишүүнтэй байсан тус эвсэл одоо 32 гишүүнтэй болоод байна. Цэрэг, улс төрийн энэ бүтцийг өргөжүүлж, дэлхийн геополитикийн том хүчин зүйл дахин болгох явдал Өрнөдийн улс гүрэн, цэрэг-аж үйлдвэрийн томоохон бүлэглэлүүдийн ашиг сонирхолд нийцэж буй нь тодорхой юм.

Ази Номхон далайн бүс нутгийн цэрэг-улс төрийн байдал ч мөн ээдрээтэй хэвээр, гол тоглогчдын хооронд ашиг сонирхлын зөрчил улам тод илэрч, илт тэмцэлдэх болов. Энэ бүс нутагт Монгол Улсаас бусад нь үндсэндээ өөр хоорондоо газар нутгийн ямар нэгэн маргаантай байгаагаас гадна Умард Солонгосын цөмийн хөтөлбөр, Өмнөд Хятадын тэнгис, Тайваний асуудал г.м зөрчил, сөргөлдөөн дэлхийн хуурай замын цэргийн хамгийн их хүч хуримтлагдсан Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Өмнөд хөрш БНХАУ-ын цэрэг-эдийн засгийн чадавх нэмэгдэхийн хэрээр түүнээс болгоомжилсон эвсэл Энэтхэг-Номхон далайн бүс нутагт шинээр байгуулагдах боллоо. 2007 онд тухайн үеийн Японы Ерөнхий сайд асан Шинзо Абегийн санаачилгаар байгуулсан АНУ, Австрали, Япон, Энэтхэг дөрвөн орны “Аюулгүй байдлын 4 талт хэлэлцээр” буюу QUAD, 2022 оны есдүгээр сарын 15-ны өдөр байгуулагдсан АНУ, Их Британи, Австрали улс хамтарсан гурван талт “AUKUS” гэрээг олон улсын аюулгүй байдал судлаачид үнэн чанартаа Хятадын өсөн нэмэгдэж буй аюулыг хязгаарлах зорилготой Өмнөд Хятадын тэнгис рүү чиглэсэн үйл ажиллагаа, “шинэ хүйтэн дайн”-ы эхлэл хэмээн харж байна. Эдгээр гэрээ, хэлэлцээр нь хэдийгээр НАТО хэмээх хүчирхэг байгууллагатай харьцуулшгүй яриа хэлэлцээрийн платформ мөн боловч богино хугацаанд Энэтхэг, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй бас нэгэн субъект болов.

Ойрх Дорнодод Сирийн нөхцөл байдал намжаагүй үед Израиль-Хамасын мөргөлдөөн гарч Газын зурвас дайны байдалтай болж хувирав. Израилийн тал Газын зурваст цэргийн ажиллагаа явуулж эхэлснээр энэ сөргөлдөөнд Ойрх Дорнодын улс орнууд татагдан орох, Израилийг дэмжсэн Өрнөдийн улс орнуудад еврей иргэдийн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа нэмэгдэх хандлагатай болов. Орос-Украины дайн дэлхийн эрчим хүч, хүнсний хямралд хүргэсний нэгэн адил Ойрх Дорнодын хямрал газрын тосны бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт болон далайн тээвэрт сөргөөр нөлөөлж олон улсын тээвэр ложистикийн систем доголдох шалтгаан болов. Эдгээр дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэлтэй нийгэм-эдийн засгийн хямрал гүнзгийрэх тусам улс төрийн ямар ч дэглэмтэй улс орнуудын дотоодын тогтвортой байдал алдагдан, хил дамнасан хүндрэл бэрхшээлүүд улам нэмэгдэнэ. Өнөөгийн байдлаар АНУ болон Европын зарим улсууд Ойрх Дорнодын хямралыг намжаах талаар ажиллаж байгаа боловч олон жилийн туршид урхаг болсон энэ хямралыг бүрэн зогсоох боломжгүй мэт харагдана.

Ийнхүү их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөн даамжирахын хэрээр олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчин улам ээдрээтэй болж цаашид хэрхэн өрнөх тодорхойгүй байгаа явдал зарим талаар жижиг улс орнуудын улс төр, бие даасан гадаад бодлогод сөргөөр нөлөөлөх шалтгаан болж болзошгүй байна. Геополитикийн том тоглогчид хоорондын зөрчил, талцал гүнзгийрснээр жижиг улс орнуудын гадаад, дотоод аюулгүй байдлын орчин тогтворгүй болох аюултай. Тухайлбал, их гүрнүүд жижиг улсуудад өөрсдийн геополитикийн зорилго, зорилтыг шахан тулгах, цэрэг-улс төр болон гео-эдийн засгийн нөлөөнд оруулах бодлогыг төр, засгийн түвшинд (хоёр болон олон талт харилцааны түвшинд) тулган хүлээлгэх, үүнийгээ тухайн улсын дотоод улс төр, нийгэм-эдийн засгийн хуваагдлыг ашиглан хэрэгжүүлэх үйл явц идэвхждэг.

Өнөөдөр дэлхийн ихэнх улс (АНУ-ын холбоотон улсуудад ч мөн адил) АНУ болон ОХУ, БНХАУ гэсэн геополитикийн сөргөлдөөний үед баримтлах байр суурь, бодлого, стратегиа тодорхойлох төвөгтэй байдалд байна. Дэлхийн эдийн засаг засаг дахь ОХУ-ын нөлөө, ач холбогдол харьцангуй бага учраас АНУ-ын холбоотнууд түргэн хугацаанд эвлэлдэн, нэгдсэн. Гэхдээ ОХУ-аас хамаарах аюулгүй байдал, эдийн засгийн хамаарал өндөр, голдуу хил залгаа улс орнуудын хувьд стратегийн сонголт хийх боломж хязгаарлагдмал хэвээр байна. Харин Америк-Хятадын геополитикийн хуваагдлын хувьд улс орнуудын байр суурь харилцан адилгүй, дийлэнх нь Хятадын эдийн засгийн боломж, зах зээлийг алдахгүй байхыг эрмэлзэж байна. АНУ-ын холбоотон улсууд эдийн засгийн харилцаагаа Хятадтай хэвээр хадгалж, гагцхүү аюулгүй байдлын чиглэлээр буюу Хятадыг тогтоон барих, олон улсын цэрэг-улс төрийн нөлөөг хязгаарлахад онцгойлон анхаарах болсон.

Олон улсын геополитикийн нөхцөл байдал цаашдаа (ойрын 5-10 жилд) улам хүндрэх, зөрчил, сөргөлдөөний тоо, цар хүрээ өргөжих хандлага тогтож байгааг томоохон судалгааны байгууллага, судлаачид хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ геополитикийн төлөв байдал, хандлага дараах гурван хүчин зүйлээс хамаарч, өөрчлөгдөж болох юм. *Нэгдүгээрт*, их гүрнүүд, ялангуяа АНУ, БНХАУ, ОХУ-ын дотоод орчинд гарах өөрчлөлт (сонгууль, нийгэм-эдийн засгийн хямрал, үймээн, тогтворгүй байдал г.м.) геополитикийн амбиц, бодлогод нөлөөлнө. *Хоёрдугаарт*, олон улсын аюулгүй байдал улам бүр тогтворгүйжиж улмаар хаос

үүсч дэлхийн дайны ирмэгт ирж, үүнийг хамтаар зогсоохоос өөр аргагүй байдалд хүрвэл их гүрнүүд хамтран ажиллаж, тохиролцоо хийх магадлалтай. *Гуравдугаарт*, дэлхийг хамарсан байгалийн гамшиг, цар тахал гэх мэт аюултай нөхцөл бүрдвэл, геополитикийн сөргөлдөөнийг түр ч болов намжаах боломж бүрдэнэ.

Хоёр. Зүүн Хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдал

Зүүн Хойд Азийн бүс нутагт “Хүйтэн дайн”-аас үүдэлтэй геополитикийн нөхцөл байдал давамгайлсан хэвээр байна. Бүс нутаг эдийн засгийн интеграцид харьцангуй сайн орсон, эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнуудаас бүрдэж байгаа боловч цэрэг-улс төр, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм байхгүй, газар нутгийн маргаантай асуудлаас үүдэлтэй зөрчил мөргөлдөөн гарах магадлал хамгийн өндөр бүс нутагт тооцогддог. АНУ-ын хувьд Хятадын цэрэг, улс төрийн нөлөөг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хязгаарлах, Америкийн геостратегийн давуу талыг хадгалах бодлогыг 2000 оноос хойш тууштай хэрэгжүүлж байна. Энэ зорилгоор геостратегийн чухал байршил бүхий түншүүд болох Тайвань, Өмнөд Солонгос, Япон дахь улс төрийн нөлөө болон цэргийн хүчин чадавхийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, чанаржуулах чиглэлд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

Зүүн Хойд Азийн хувьд дэлхийн бусад бүс нутагтай харьцуулахад удаан хугацааны турш цэрэг, зэвсгийн маш том төвлөрөл бий болсон. Ким Жон Ун Умар Солонгосын төрийн эрхийг авснаас хойш зэвсэглэлээр идэвхитэй хөөцөлдөж, тив алгасагч баллистик пуужин, цөмийн зэвсэг, устөрөгчийн бөмбөгийн зэрэг туршилтуудыг удаа дараалан хийж, АНУ, БНСУ, Япон улсыг илт заналхийлж байгаа нь бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн нэг болж байна. Энэ хүрээнд БНСУ, Япон батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлж АНУ-тай хамтарсан цэргийн сургуулиудыг тоо, цар хүрээг нэмэгдүүлж байна.

Зүүн Хойд Азийн бүс нутгийн харьцангуй тогтвортой байдлыг хэвээр хадгалж, зарим талаар тэнцвэржүүлэхэд одоогоор дараах хүчин зүйлс нөлөөлж байна, гэж болно. Үүнд:

- НАТО-гийн бодлогын эсрэг Орос, Хятадын стратегийн түншлэл;
- Өмнөд хятадын тэнгист явуулж буй Хятадын бодлогын эсрэг тус улстай газар нутгийн маргаантай бусад орнуудын түншлэл;
- Умард Солонгосын асуудлаар бүс нутгийн орнуудын баримталж буй бодлого;
- Бүс нутгийн нөлөө бүхий улс орнууд (ОХУ, БНХАУ)-ын улс төрийн дэглэм хүчтэй хэвээр, шашин болон үндэстэн хоорондын маргаан харьцангуй намжмал байгаа;
- ШХАБ, АСЕАН болон “Бүс ба зам” зэрэг эдийн засгийн хөгжлийг суурь болгосон эвсэл, санаалчилга эрчтэй байгаа зэрэг болно.

Гэвч, бүс нутгийн нөлөө бүхий улсууд үүссэн асуудлыг үл харгалзан өнгөн дээрээ стратегийн түншлэлийг бэхжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэл болгосон мэт харагдаж байгаа ч геополитикийн зөрчил даамжирч, үндэсний эрх ашгаа хамгаалахаа хүрэхэд тогтвортой байдал хэр удаан үргэлжлэхийг урьдчилан тодорхойлоход хүндрэлтэй юм.

Солонгосын хойгийн асуудал, Өмнөд хятадын тэнгис дэх газар нутгийн маргаан, салан тусгаарлах үзэл зэргээс үүдэлтэй зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд түүхийн улбаатай зөрчил, гомдол дахин сэргэж, бүс нутгийг бүхэлд нь хамрах магадлал байсаар байна.

Хятадын хувьд эдийн засгийн өсөлтийг хадгалах, цаашид Хятадын эдийн засгийг түшиглэсэн, дэмжсэн бүс нутгийн болон олон улсын тогтолцоог бүрдүүлэх боломжийг эрэлхийлсэн геополитикийн томоохон санал, санаачилгуудыг хэрэгжүүлж байна. Түүнчлэн эдийн засгийн өсөлтөд шаардлагатай түүхий эдийн нөөцийг бүрдүүлэх, худалдааны гарц, дэд бүтцийг бэхжүүлэх, зайлшгүй тохиолдолд өөрийгөө хамгаалах хэрэгцээ нэмэгдэж, үүний тулд цэргийн хүчин чадавхиа өсгөж байгаа нь тодорхой. Хэдийгээр судлаачид Тайванийг хүчээр нэгтгэх Хятадын бодлого, цаг хугацааны тодорхой зорилтын хүрээнд хэрэгжиж байна хэмээн таамаглах боловч Америк, Хятад хоёуланд асуудлыг хурцатгах, олон улсыг хамарсан зэвсэгт мөргөлдөөн, дайн үүсгэх сонирхол төдийлөн ажиглагдахгүй байна. Ийм нөхцөл байдалд орохыг бүс нутгийн улсууд, үндэстэн дамнасан олон улсын корпорациуд ч төдийлөн хүсэхгүй байна. Орос-Украины дайнаас улбаатай геополитикийн талцал Бээжинд “нэгийг харж хоёрыг бодогдуулж” байгаа нь тодорхой юм.

Дээр дурдсанчлан ЗХА-ийн бүс нутгийн хамгийн халуун цэг бол Солонгосын хойгийн асуудал юм. Хэдийгээр олон улсын байгууллага, ялангуяа, АНУ болон Өрнөдийн улс орнуудын шахалтаар Хойд Солонгосын эсрэг удаа дараа эдийн засгийн хориг арга хэмжээ авсан боловч, эдгээр хориг арга хэмжээний үр дүн, ач холбогдол унаад байна. Орос-Украины дайны нөхцөл байдал болон Америк-Хятадын худалдааны дайн Умард Солонгосын хувьд эдийн засгаа сэргээх, Орос, Хятадтай худалдаа, эдийн засгийн харилцааг улам хөгжүүлэх боломж олголоо. Пеняний зүгээс Өмнөд Солонгос, Япон цаашлаад АНУ-д цөмийн цохилт өгөх чадвартай болсон гэдгээ зарлан тунхаглаж байгаа боловч, өнгөрсөн 30 жилийн хугацаанд АНУ-тай энхийн хэлэлцээр байгуулах, харилцааг хэвийн болгох ганцхан шаардлагыг тууштай тавьж байна.

Зүүн Хойд Азийн геостратегийн давуу талыг түшиглэн Энэтхэг-Номхон далайн бүс нутагт АНУ тэргүүтэй холбоотнууд нөлөө, байр сууриа бэхжүүлсээр ирлээ. Гэвч бүс нутагт АНУ-ын хоёр том холбоотон болох Япон, Өмнөд Солонгосын хоорондын харилцаа ярвигтай, эрх баригчид дотоодын улс төрийн нөхцөл байдлаас үүдэн зарим тал дээр бие даасан бодлого баримтлах, бага зэрэг зөрчилдөх байдал ажиглагдсаар буй. Вашингтоны хувьд Токио, Сөүлтэй бүс нутаг дахь холбоотнуудын харилцаагаа улам бэхжүүлэх арга хэмжээ авч байна. Үүний тод жишээ нь Япон, БНСУ-тай гурвалсан түншлэлийг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд 2023 онд гурван талт дээд хэмжээний уулзалтыг сэргээсэн явдал юм.

Вашингтоны зүгээс Номхон далайн бүс нутаг дахь 70 гаруй жилийн түүхтэй аюулгүй байдлын гэрээтэй хоёр холбоотондоо түүхэн үл ойлголцлоо хойш тавьж аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдалд илүү нягт хамтран ажиллах шаардлага тавьж, энэхүү хамтын ажиллагаанд ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Тухайлбал, БНХАУ, ОХУ, БНАСАУ-ын харилцаа илүү ойртон улам бүр Өрнөдийн эсрэг байр сууриа нэгтгэх болсон, БНХАУ-ын зүүн болон өмнөд хятадын тэнгист явуулж буй бодлого, үйл ажиллагаа, БНАСАУ-ын улам бүр эрчимжиж буй цөмийн болон пуужингийн хөтөлбөр зэрэг нь эдгээр гурван улсын

аюулгүй байдлын нийтлэг сорилт болж энэ энэхүү гурван талт харилцаа бэхжих суурь болж байна.

Японы хувьд БНХАУ-ын өсөн нэмэгдэж буй эдийн засаг, цэргийн хүчин чадлаас ихээхэн болгоомжилж сорилт хэмээн үзэж буй бол БНСУ-ын хувьд БНАСАУ-ын улам бүр эрчимжиж буй цөмийн болон пуужингийн туршилтаас ихээхэн болгоомжилж бжй явдал энэхүү хамтын ажиллагааны гол суурь болж байна.

БНХАУ-ын зүгээс энэхүү гурван улсын гурван талт харилцаанд ихээхэн шүүмжлэлтэй хандаж буй бөгөөд Номхон далайн бүс нутагт бий болж буй жижиг НАТО хэлбэрийн гурван талт аюулгүй байдлын холбоо гэж үздэг.

ЗХА-ийн аюулгүй байдлыг тогтоон барих олон оролдлогыг бүс нутгийн улсуудаас санаачилж байдаг ч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Түүгээр ч зогсохгүй тус бүс нутгийн аюулгүй байдлын нөхцөл байдал улам бүр тогтворгүй болж байгаа явдал ЗХА-д тогтоон барих чадавх, хүчний тэнцвэр улам бүр алдагдаж буйг илтгэж буй. Зарим судлаачдын харж буйгаар бүс нутгийн өнөөгийн байдал дэлхийн хоёр удаагийн дайн эхлэхийн өмнөх Баруун Европын нөхцөл байдалтай улам төстэй болж байна¹.

Зүүн Хойд Азийн улс гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчилдөөнийг Өрнөдийн шинжээчид нэг талаас авторитар дэглэмтэй ОХУ, БНХАУ, БНАСАУ болон ардчилсан либерал засаглалтай АНУ, Япон, БНСУ-ын дэглэм хоорондын, нөгөө талаас улс хоорондын улс төр, эдийн засаг, газар нутгийн төлөөх өрсөлдөөн хэмээн тодорхойлдог. Гэвч эдүгээ энэ бүс нутагт өрнөж буй зөрчилдөөнийг ардчилал болон авторитар дэглэмийн тулгаралт хэмээн тодорхойлох нь хэт өнгөцхөн дүгнэлт болно. Энэхүү зөрчилдөөн бүхэлдээ олон улсын харилцааны тогтолцооны өөрчлөлтийг шаардсан үйл явцын Ази дахь өрнөл хэмээн үзэх нь илүү ойр юм.

Товчхондоо, Зүүн Хойд Азийн бүс нутагт геополитикийн зөрчил, сөргөлдөөн гарах магадлал өндөр боловч, талууд асуудлыг хоёр талын яриа хэлэлцээний механизмаар шийдвэрлэх, цар хүрээг тэлэхээс болгоомжилсон байдалтай байна. Тайваныг нэгтгэх асуудлаарх Хятадын байр суурь Тайваны дотоод улс төрийн өрнөлийг ажигласан байртай байгаа бол харин АНУ Тайванийг Хятадын эсрэг “хөзөр” байдлаар ашиглаж, геостратегийн давуу байдлаа сануулахад хэрэглэж байна. Гэхдээ бүс нутагт зэвсэглэлээр хөөцөлдөх явдал цаашид нэмэгдэж, улмаар “Хүйтэн дайн”-ы үеийн харилцааны хэв маяг давамгайлж болох юм.

Гурав. Аюулгүй байдлын гадаад орчноос Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч болзошгүй эрсдэл, сорилт

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин бүс нутгийн аюулгүй байдал, юуны түрүүнд хоёр хөрш ОХУ болон БНХАУ-ын аюулгүй байдлаас шууд хамааралтай билээ. Хэдийгээр хөрш хоёр оронтойгоо ямар нэгэн зөрчилгүй, эрх тэгш харилцаатай мэт боловч их гүрнүүдийн нөлөө, дарамт шахалт манай улсын аюулгүй байдал, эдийн засгийн бүх салбарт бодитой оршиж энэ ч утгаараа эрсдэл², сорилт³ үүсгэж байна. Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин

¹ Базарваань Г., нар “Зүүн Хойд Азийн бүс нутгийн нөхцөл байдал: Монгол Улсын анхаарах асуудал” (судалгаа) УБ.2023

² Аюул учрах магадлал түүнээс үүсэх сөрөг үр дагавар

³ хувь хүн, нийгэм болон төр улсын өмнө тулгарч буй “хүнд бэрх шалгуур”

ОХУ-тай харилцах харилцаа, БНХАУ-тай харилцах харилцаанаас тусдаа хамааралтай хэдий ч Орос-Хятадын хоорондын харилцаанаас шууд хамаарч түүхэн цаг үеийн туршид элдэв эрсдэл, сорилт бэрхшээтэй тулгарч ирсэн бөгөөд цаашид ч тулгарсаар байх нь тодорхой байна. Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэлийн (comprehensive strategic interaction partnership) түвшинд хүрсэн явдал Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд хамгийн ойр, таатай нөхцөлд байна гэж үзэж болох талтай.

Түүхээс харахад энэ хоёр улсын харилцаа эерэг байхад Монгол Улсад болон бүс нутагт нааштай нөлөөтэй байх хандлагатай байдаг. Монгол Улсын хувьд энэ харилцаа хэт ойртох асуудал мөн аюултай байж болно. Тухайлбал 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монгол Улсын тусгаар тогтносон нэгдсэн улс байх хүсэл эрмэлзлийг няцааж, хоёр хөршийн эрх ашгийг хангасан байдаг. Москва, Бээжингийн харилцаа эерэг байснаараа манай улсад аль нэг талыг сонгох шаардлага бий болохгүйн зэрэгцээ хоёулантай нь найрсаг харилцаагаа хадгалаад явах боломж илүү юм. Нөгөө талаас хоёр хөрш улс Монгол Улсад үзүүлэх нөлөөний хувьд бие биеэсээ болгоомжлох, тодорхой хязгаарт барьж байх нөхцөл байж болно.

Орос, Хятадын харилцаа өнөөгийн байдлаар үргэлжлэх магадлал хамгийн өндөр юм. Энэ харилцаанд Украины дайн хэрхэн төгсөх, Тайванийн хоолойн асуудал, БНХАУ, АНУ-ын харилцаа, ОХУ, НАТО-гийн зөрчил зэрэг асуудал гол нөлөөтэй байх болно. Зүүн Хойд Азийн орон зайд БНХАУ, ОХУ, БНАСАУ гурвалсан байдлаар Өрнөдийн эсрэг байр сууриа улам бүр нэгтгэх, нөгөө талаас энэ гурвын эсрэг АНУ, Япон, БНСУ холбоотны харилцаагаа бэхжүүлсээр байгаа нь улам бүр тодорхой болж байна. Энэ нь бүс нутгийн хурцадмал байдлыг улам нэмэгдүүлж байгаа бөгөөд хурцдах тусам манай улсын хувьд сонголт хийх шаардлага, шахалт бий болох эрсдэлтэй юм.

Украины дайны улмаас ОХУ-ын байр суурь, хүч ихээхэн буурах нь энэ харилцаанд эзлэх БНХАУ-ын байр суурь, нөлөөг улам бүр нэмэгдүүлнэ. Өрнөдийн орнуудын хоригт орсон ОХУ-ын хувьд Дорно зүгт харилцаагаа чиглүүлэхээс өөр гарцгүй бөгөөд энэ харилцаанд БНХАУ-ыг түшихээс өөр сонголтгүй болж байна. БНХАУ-ын хувьд энэ харилцаанд прагматик байдлаар хандаж, өөрийн ашиг сонирхлыг хангаж, асуудалд сонголттойгоор хандана. Энэ тохиолдолд бүс нутагт болон Монгол Улс дахь өмнөд хөршийн нөлөө нэмэгдсээр байх юм.

Монгол Улсын геополитикийн орчны өвөрмөц байдал болон олон улсын харилцаанд хүчний тэнцвэрийг блокт хуваагдах замаар хангах тохиолдолд бид өөрийн гадаад аюулгүй байдлын орчин, эдийн засагт нөлөөтэй их гүрнийг дагах нөхцөл үүсч болзошгүй. Орос-Өрнөдийн сөргөлдөөнд Өрнөдийнхөн, хоёр хөршийн харилцаанд БНХАУ тэргүүлэх хийгээд АНУ-БНХАУ-ын хооронд хүчний тэнцвэр хадгалагдах аль ч тохиолдолд хөрш хоёр улс манай улсад дарамт шахалт үзүүлэх бүрэн боломжтой.

АНУ болон БНХАУ-ын хооронд хүч тэнцэх тохиолдол ч мөн адил бидний хүсэх сценари биш. Учир нь бид хоёр талаас үзүүлэх улс төр, эдийн засгийн шахалтын тэнцвэрийг хадгалах эрсдэлтэй нөхцөл байдалтай тулгарна.

Хүчний нөлөөг тэнцвэржүүлэх үндсэн нөхцөл нь хараат байдлаас гарах асуудал байдаг. Олон улсын харилцаанд хүчний тэнцвэр өөрчлөгдөх, блокт хуваагдах процесс түргэн өрнөхгүй. Иймээс дунд болон удаан хугацаанд аль нэг

хөршөөс хараат бус орших үйл ажиллагаа явуулах бол манай үндсэн алсын хараа болно. Гэвч урд хөршөөс эдийн засгийн хувьд хараат бус байх боломж улам бүр хомсдож байна. Хэдийгээр цөөнгүй “гуравдагч хөрш” улстай стратегийн түншлэл тогтоож, Франц, Япон, Энэтхэг зэрэг улстай стратегийн нэн чухал салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх нааштай алхам хийж байгаа ч хэрэв хүчний тэнцвэрийн өнөөгийн байдал алдагдаж, бидний таамаглалаар өрнөвөл хоёр хөрш өөрсдийн нөлөөг бэхжүүлэх улс төр болон эдийн засгийн дарамт үзүүлэх эрсдэл бий. Иймд хүчний тэнцвэр алдагдах тохиолдолд бид хүссэн ч эс хүссэн ч БНХАУ-ын макро сонирхлын бүсэд хамрагдах нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Монгол Улс ОХУ-тай 2019 онд “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээ”-г хугацаагүйгээр байгуулсан нь хоёр орны шинэ үеийн харилцааны итгэлцлийн түвшинг тодорхойлсон чухал үйл явдал болсон. Гэвч Умард хөршөөс ирэх улс төрийн дарамт шахалт, стратегийн төслүүдийг гацаах явдал ил болон далд хэлбэрээр гарч байгаа нь эрчим хүч, төмөр зам, уул уурхай, батлан хамгаалах зэрэг салбаруудыг хараат байлгах гэсэн бодлоготой холбоотой юм. ОХУ Гадаад бодлогын үзэл баримтлал баримт бичигтээ анх удаа “Монгол Улстай уламжлалт, нөхөрсөг харилцааг бэхжүүлнэ” гэж тусгайлан онцлон, нэр зааж томьёолсон. Энэ нь Монгол Улстай явуулах Оросын бодлого урьдын уламжлалт байдлаа хэвээр хадгалсан хандлагатай байх болно гэсэн итгэлийг бий болгож байна.

Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагаа эдүгээ Иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрч, шийдвэрлэгдээгүй, маргаантай асуудалгүй, түүхэн дэх хамгийн таатай үедээ байгаа хэдий ч урд хөршөөс манай улсад тодорхой хэмжээгээр ил болон далд хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх байдал илрэх болсон. Энэ нөхцөлийг бүрдүүлж буй гол хүчин зүйл болсон эдийн засаг, худалдааны хэт хараат байдал нь айлын талд давуу байдал олгож, зарим талаар шахалт үзүүлэх “хөзөр” болж байна. Монгол Улсын үе үеийн Засгийн газрын зүгээс БНХАУ-ын “Нэг Хятад”-ын бодлогыг хүндэтгэж ирсэн төдийгүй харилцан бие биенийхээ бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрч, улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг баримталж ирсэн. Гэвч хоёр талын харилцаанд үе үе таагүй уур амьсгал үүсгэдэг зарим асуудал оршсоор байна.

БНХАУ-ын хөрөнгө оруулалт манай улсад төдийгүй дэлхийн олон улсад эдийн засгаа богино хугацаанд хөгжүүлэх боломж олгож байгаа ч нөгөө талаар Хятадын нөлөө, “Өрийн урхи”-нд орох эрсдэлийг нэмэгдүүлж байна. БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд хөгжиж буй улс орнууд өрийн хавханд орж болзошгүй талаар олон улсын байгууллагууд анхааруулах болсон. Сүүлийн үеийн томоохон бүтээн байгуулалтыг БНХАУ-ын зээл, санхүүжилтээр барьж буй бидэнд өрийн дарамт үүссэн тохиолдолд Хятадын байр суурийг дэмжих, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт нэгдэн орох зэрэг улс төр, эдийн засгийн шахалт ирж болзошгүй юм.

Цаашид хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд болгоомжтой хандах, өр зээлийн барьцаанд орохоос сэргийлэх, зээлийн нөхцөл болзлуудыг сайтар судлах, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй байдлыг бэхжүүлэхийн тулд бусад орнуудын хөрөнгө оруулалтыг дэмжих, уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг түүхийгээр нь цорын ганц зах зээлд гаргадаг байдлыг зогсоож бусад улсын

хөрөнгө оруулалтаар болон бусад эх үүсвэрээр боловсруулах үйлдвэр барих, эцсийн бүтээгдэхүүн болгон гуравдагч зах зээлд гаргах боломжийг бий болгох, хөдөө аж ахуйн эко бүтээгдэхүүний экспортыг дэмжиж нэмэгдүүлэх хэрэгтэй.

Хоёр хөршөөс манайд үзүүлж буй дарамт шахалт нь манай улсаас АНУ болон түүний ойрын холбоотон улс орнуудтай хөгжүүлж буй “гуравдагч хөрш”-ийн бодлого, үйл ажиллагаатай зарим талаар холбоотой байж болох талтай. АНУ-тай тогтоосон харилцаа, ялангуяа олон улсын энхийг сахиулах болон терроризмтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагаа нь Монголд ардчиллыг хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийг бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой, манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болон хувирч байна. Хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа цаашид гүнзгийрэх бололцоо ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь нэг талаас дэлхийн хамгийн хүчирхэг, нөлөө бүхий гүрний ивээл дор эдийн засаг, нийгмийн хөгжил, аюулгүй байдлын зарим асуудлыг амжилттай шийдвэрлэх бололцоог бий болгож байгаа ч нөгөө талаас үүнд хөрш том гүрнүүдийн зүгээс болгоомжлон хандах болсон нь аюулгүй байдлын гадаад орчны үүдэлтэй стратегийн шинэ эрсдлийг авчирч болзошгүй бас нэг шинэ сорилтыг бий болгож байна.

Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд АНУ-аас манай руу чиглэсэн гадаад бодлого нь ардчилал, хүний эрхийг хамгаалсан улс төрийн тогтолцоог бэхжүүлэх, хувийн өмчид тулгуурласан эдийн засгийн бүтэцтэй болгоход чиглэж, хоёр хөршийн нөлөөнд автахгүй байх төр, засгийн бодлогыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаанд төвлөрч байв. Манай улсаас хөрш улсуудтай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаанд нөлөөлөхгүй байх үндсэн зарчмыг АНУ-ын тал хүлээн зөвшөөрдөг. Харин манай улсын газарзүйн өвөрмөц байрлал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь АНУ-ын геополитикийн сонирхлыг татдаг учраас аюулгүй байдлын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг илэрхий эрмэлздэг. Гэвч улс төрийн харилцааг зарим тохиолдолд хөрш орнуудын эсрэг явуулж буй цаг үеийн тоглолтод ашиглах оролдлого ажиглагддаг. Тухайлбал, Бээжингийн хүний эрхийг хөсөрдүүлж байгаа асуудлыг манай улсад хийгдэж буй томоохон айлчлалуудын үеэр онцлох, хүний эрхийн асуудлаарх Хятадын эсрэг чиглэсэн олон улсын санал, санаачилгыг дэмжих, Орос-Украины дайныг эсэргүүцэхийг шаардах зэрэг зарим үйлдлийг жишээ болгон дурдаж болно.

Хятадтай сөргөлдөхөд чиглэсэн “Эрх чөлөөт, нээлттэй Энэтхэг Номхон далай” санаачилгад Монгол улсыг оролцогч улсаар онцлон, энэ хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэхийг АНУ-ын засаг захиргаа эрмэлзэх болсон нь нэг талаар, жижиг улсын тусгаар тогтнолыг хамгаалах, эдийн засгийн хамтын ажиллагаанд, дэмжлэг үзүүлэх, Ази, Номхон далайн интеграцид ороход тус дөхөмтэй боловч нөгөө талаар, Хятадтай шууд сөргөлдсөн стратеги болж хувирвал манай гадаад бодлогод төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэх эрсдэлтэй.

Хоёр хөршийн хувьд манай улсаас АНУ-тай тогтоосон улс төр, эдийн засаг, соёлын харилцааг эсэргүүцсэн бодит баримт байхгүй гэдгийг онцлох нь зүйтэй.

Монгол Улс 2004 оноос ШХАБ-д ажиглагчийн статусаа хадгалж ирсэн бөгөөд тус байгууллагын тэргүүлэгч болох хоёр хөршийн зүгээс манайхыг бүрэн эрхт гишүүн болгон шат ахиулах сонирхолоо ил, далд хэлбэрээр илэрхийлсээр байна. ШХАБ-ын хөгжлийн баримт бичгүүдэд тавьсан зорилтууд нь эдийн засгийн

хамтын ажиллагааны чиглэлээр бодитой хэрэгжүүлэх төлөвлөгөө, замын зураглалгүй тунхаг төдий хэвээр байгаагаас харахад бидэнд эдийн засгийн боломж олж авах нааштай дүр зураг төдийлэн харагдахгүй байна. Төв Азийн орнуудын хилийн маргаан, хоорондын зөрчлийг шийдвэрлэх гэсэн ШХАБ-ын анхны үндсэн зорилго хэвээр байгаа тул бүс нутгийн орнуудтай улс төр, газар нутгийн аливаа маргаангүй Монгол Улсын тухайд эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь эн тэргүүний зорилт гэдгийгээ хэт болгоомжилсон бус байр сууринаас хоёр хөршдөө зөв ойлгуулж, өнөөгийн оролцоо, байр суурийг хэвээр хадгалвал зохино.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн улсын хувьд бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, яриа хэлэлцээний механизм бий болгох хүчин чармайлтыг Монгол Улс ямагт дэмжиж ирсэн. Тухайлбал, 2013 онд Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг дэвшүүлж, бүс нутгийн орнуудад албан ёсоор зарласан. Санаачилгын хүрээнд ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2014 оноос хойш, цар тахлын үед завсарласныг эс тооцвол жил бүр уламжлал болгож зохион байгуулж ирсэн. Манай санаачилга ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх бусад санаачилгыг үгүйсгэх юм уу, эсвэл өрсөлдөхгүй. Монгол Улсын санаачилга Солонгосын хойгийн асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, Зүүн Хойд Азид итгэлцлийг бэхжүүлэх, энх тайвныг цогцлооход дэмжлэг үзүүлэх, бүс нутагт хамтын ажиллагааны бодит механизм үүсгэх хөрсийг бүрдүүлэх, аюулгүй байдлын сорилтыг бууруулахад хувь нэмэр оруулах үндсэн зорилготой. Иймд энэхүү санаачилгыг шат ахиулах, бүс нутгийн яриа хэлэлцээний платформ болгох асуудлыг дэвшүүлэх шаардлагатай болно.

Дүгнэлт

Нэг талаас АНУ, Япон, БНСУ нөгөө талаас БНХАУ, ОХУ, БНАСАУ гэсэн гурвалаар улам бүр хуваагдаж, харьцангуй тогтвортой мэт боловч аюулгүй байдлын тулгамдсан асуудал ихээр хуримтлагдсан Зүүн Хойд Азийн бүс нутагт оршин буй Монгол Улсын хувьд бүс нутгийн улс орнуудтай харилцах харилцаандаа улам бүр мэдрэмжтэй хандах шаардлагыг бий болгож байна.

Олон улсын амьдрал олон туйлт систем рүү шилжих тохиолдолд хүчний харьцаа хэрхэн өөрчлөгдөх, хичнээн туйл үүсэх тухай асуудал олон улсын харилцаа, аюулгүй байдал судлалын салбарын анхаарах үндсэн судалгааны объект болж байна. Иймд, бидний хувьд хоёр хөрш ОХУ, БНХАУ-аас гадна Ази Номхон далайн бүс нутагт нөлөөтэй АНУ-ын үндэсний аюулгүй байдлын суурь баримт бичийг судлах нь аюулгүй байдлаа хангах, болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож, үүнтэй уялдуулан бодлого, стратегия боловсруулж, хэрэгжүүлэхэд онц шаардлагатай юм.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.
2. The 2022 National security strategy of the USA.
3. Стратегия национальной безопасности РФ. 2021.
4. Батжаргал П. Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй эрсдлийн онол, практикийн шинжилгээ.

Пурэвдоржийн Батжаргал. Дэлхийн геополитикийн өөрчлөлт зүүн хойд азийн бүс нутаг болон монгол улсын аюулгүй байдалд нөлөөлөх нь

5. Зүүн Хойд Азийн бүс нутгийн нөхцөл байдал: Монгол Улсын анхаарах асуудал. ССХ, хамтарсан судалгаа.

Нийтлэлийг 2024 оны 11 сарын 7 өдөр редактор хүлээн авсан; хянан үзээд 2024 оны 12 сарын 9 өдөр баталсан; 2024 оны 12 сарын 12 өдөр хэвлүүлэхээр хүлээн зөвшөөрсөн.

Global Geopolitical Changes and Their Impact on Security in Northeast Asia and Mongolia

Purevdorzhin Batjargal
lead researcher
Institute of Strategic Studies,
National Security Council of Mongolia
State House 11, 8th floor,
11 Sambuug Street, Chingeltei District,
Ulaanbaatar 15141, Mongolia
batjargal@iss.gov.mn

Abstract. The contemporary international situation is rapidly evolving, becoming increasingly unstable and unpredictable. Major transitions and shifts are occurring in international relations and geopolitics. Local conflicts, influenced by adverse military-political factors, escalate into acute phases, further deteriorating and complicating the global security environment. Northeast Asia is no exception, as it continues to face a geopolitical landscape shaped by the remnants of the “Cold War”. While the region includes economically developed and relatively well-integrated countries, it lacks effective mechanisms for building trust and cooperation in the sphere of security. Currently, Northeast Asia is regarded as a region with a high likelihood of conflicts arising from territorial disputes.

Keywords: new world order, risks and challenges, Northeast Asia, Mongolia.

For citation

Purevdorzhin Batjargal. Global Geopolitical Changes and their Impact on Security in Northeast Asia and Mongolia. *Oriental Vector: History, Society, State*. 2024; 4: 50–61 (In Mong)

The article was submitted 07.11.2024; approved after review 09.12.2024; accepted for publication 12.12.2024.